



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төвийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДАА-2025/116/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дархан-Уул аймаг

2024 он

Газрын дарга, тэргүүлэх аудитор: Ш.Мөнхбаяр

Утас: 70373089, 99023682

Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер: У.Батсүрэн

Утас: 99023682

Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор: С.Батцэцэг

Утас: 99377479

Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Пийк-Ом Аудит ХХК

Захирал: Б.Жаргалсайхан

Утас: 99862066

Цахим хаяг: peakomaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	16
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	19

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ хвдалдан авах



ОРХОН СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ТӨВИЙН ДАРГА А.БАТГЭРЭЛ ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2025.02.25 № 143

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төвийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Төсвийн шууд захирагчийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 52,121.9 мянган төгрөгийн хууль тогтоомж, холбогдох тушаал шийдвэрийг биелүүлж ажиллаагүй, ажил гүйлгээг бүртгэхдээ НБББББ-ийг мөрдөөгүй зэрэг зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс хэтэрсэн бөгөөд дангаараа буюу нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, УСНББОУС болон холбогдох хууль, журамд нийцээгүй санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Иж бүрэн байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд Эрүүл мэндийн сайдын 2024 оны А/400 тоот тушаалаар 208,699.4 мянган төгрөгийн түргэн тусламжийн иж бүрэн тоноглогдсон автомашин, Дархан-Уул аймгийн Нэгдсэн эмнэлгээс 31,500.0 мянган төгрөгийн УАЗ- фургон автомашиныг тус тус хүлээн авч данс бүртгэлд тусгасан, Дархан-Уул аймгийн Орон нутгийн өмчийн газрын 2024 оны А/34 дүгээр тушаалаар 65,000.0 мянган төгрөгийн усны халаалтын зуухыг Орхон тохижилт үйлчилгээний газарт шилжүүлсэн байна.

4525020239

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоосноор цалингийн зардал өнгөрсөн оны гүйцэтгэлээс 35.3 хувиар өссөн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төв нь байгууллагын 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 8 зорилтын хүрээнд 25 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжүүлснийг 94.0 хувиар дүгнэсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.МӨНХБАЯР

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	241,965,797.16	248,134,103.52
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	104,823,711.73	-
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	104,823,711.73	-
31210	Төгрөг	104,823,711.73	-
31211	Төрийн сангийн харилцах	104,823,711.73	-
33	АВЛАГА	18,005,092.31	128,520,952.80
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	5,198,367.31	3,181,469.60
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	12,806,725.00	125,339,483.20
35	БАРАА МАТЕРИАЛ	119,136,993.12	119,613,150.72
35100	Түүхий эд материал	77,775,288.09	75,954,418.49
35110	Тусгай зориулалттай материал	6,044,600.00	6,044,600.00
35130	Эм боох материал	71,730,688.09	69,909,818.49
35400	Хангамжийн материал	41,361,705.03	43,658,732.23
35410	Бичиг хэргийн материал	710,480.00	968,750.00
35420	Аж ахуйн материал	38,458,927.23	42,408,548.23
35440	Түлш, шатах тослох материал	1,987,371.00	225,228.00
35460	Хүнсний материал	204,926.80	56,206.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	688,856,596.72	768,880,906.94
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	688,856,596.72	768,880,906.94
39200	Биет хөрөнгө	684,009,751.04	764,080,906.94
39201	Барилга, байгууламж, орон сууц	498,438,445.00	498,438,445.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(52,615,828.29)	(66,259,307.01)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	50,436,434.00	261,835,800.47
39204	Хуримтлагдсан элэгдэл	(39,211,434.01)	(69,289,342.86)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	277,794,079.33	285,579,537.79
39206	Тавилга, аж ахуйн эд хогшил	42,181,490.00	40,244,310.00
39207	Хуримтлагдсан элэгдэл	(16,282,984.36)	(20,872,935.12)
39208	Зам, гүүрийн байгууламж	4,000,000.00	4,000,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,666,667.20)	(2,866,667.24)
39214	Бусад үндсэн хөрөнгө	75,095,510.00	12,651,510.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(6,808,848.92)	(7,502,352.18)
39300	Биет бус хөрөнгө	4,846,845.68	4,800,000.00
39301	Програм хангамж	1,124,300.00	1,124,300.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,077,454.32)	(1,124,300.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,800,000.00	4,800,000.00
3	НИИТ ХӨРӨНГИЙН ДҮН III=II	930,822,393.88	1,017,015,010.46
4	НИИТ ӨР ТӨЛБӨР	9,151,777.00	86,625,132.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	9,151,777.00	86,625,132.00
41300	Өглөг	9,151,777.00	86,625,132.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	-	74,315,923.95
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	9,151,777.00	12,161,208.05
41360	Бусад өглөг	-	148,000.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	148,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	921,670,616.88	930,389,878.46
51	Засгийн газрын хувь оролцоо	921,670,616.88	930,389,878.46
51100	Засгийн газрын оруулсан капитал	156,678,198.05	156,678,198.05
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	156,678,198.05	156,678,198.05
51200	Хуримтлагдсан үр дүн	344,720,395.55	353,439,657.13
51210	Өмнөх үеийн үр дүн	496,688,078.57	344,720,395.55
51220	Тайлант үеийн үр дүн	(151,967,683.02)	8,719,261.58
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зарвуу	420,272,023.28	420,272,023.28
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	930,822,393.88	1,017,015,010.46

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	710,376,203.28	1,197,378,913.03
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,657,470.92	234,955,333.93
120	Нийтлэг татварын бус орлого	20,657,470.92	234,955,333.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	251,000.00	-
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	251,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,004,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	15,719,488.96	218,415,284.93
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	4,686,981.96	8,536,049.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	689,718,732.36	962,423,579.10
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,798,100.00	69,051,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,798,100.00	69,051,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	621,920,632.36	893,372,079.10
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	621,920,632.36	893,372,079.10
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	862,343,886.30	1,123,659,651.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	862,343,886.30	1,123,659,651.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	835,548,939.74	1,094,380,406.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	489,075,433.87	729,084,243.11
210101	Үндсэн цалин	265,598,893.89	359,459,000.03
210102	Нэмэгдэл	177,319,653.21	290,032,083.08
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,022,820.39	12,416,000.00
210104	Урамшуулал	34,134,066.38	67,177,160.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,479,710.64	89,562,307.01
210201	Тэтгэврийн даатгал	48,106,410.84	60,934,661.89
210202	Тэтгэмжийн даатгал	5,343,700.00	7,366,524.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,274,300.00	4,815,020.55
210204	Ажилгүйдлийн даатгал	1,068,700.00	3,289,219.98
210205	Эрүүл мэндийн даатгал	10,686,599.80	13,156,880.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,262,153.44	37,049,754.65
210301	Гэрэл, цахилгаан	5,604,636.44	7,299,581.65
210302	Түлш, халаалт	27,697,237.00	27,585,793.00
210303	Цэвэр, бохир ус	3,960,280.00	2,164,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	42,447,114.97	29,738,382.40
210401	Бичиг хэрэг	11,017,367.50	5,566,280.00
210402	Тээвэр, шатахуун	9,766,845.00	10,662,143.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,584,203.60	2,894,395.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	145,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,933,698.87	10,495,564.00
2105	Нормативт зардал	101,544,629.74	114,320,938.22
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	84,327,376.54	97,682,372.42
210502	Хоол, хүнс	10,541,203.20	14,399,565.80
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,676,050.00	2,239,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,343,646.00	13,427,760.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,006,000.00	779,000.00
210604	Урсгал засвар	5,337,646.00	12,648,760.00
2107	Томилот, зочны зардал	410,000.00	434,000.00
210702	Дотоод албан томилот	410,000.00	434,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,839,437.00	2,948,886.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,897,200.00	2,006,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	124,749.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,237.00	97,737.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	-
210807	Газрын төлбөр	60,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	83,146,814.08	77,814,134.71
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,839,980.00	513,180.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	76,306,834.08	77,300,954.71
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	8,004,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,004,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,004,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,794,946.56	21,275,245.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,794,946.56	21,275,245.35
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(151,967,683.02)	73,719,261.58
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	65,000,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	65,000,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(151,967,683.02)	8,719,261.58

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	677,163,007.36	857,894,820.90
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	251,000.00	8,004,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	251,000.00	8,004,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	251,000.00	8,004,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	251,000.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	8,004,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	676,912,007.36	849,890,820.90
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	67,798,100.00	69,051,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	67,798,100.00	69,051,500.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	609,113,907.36	780,839,320.90
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	609,113,907.36	780,839,320.90
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	759,771,759.42	958,808,552.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	759,771,759.42	958,808,552.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	732,976,812.86	929,529,307.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	494,273,801.18	680,240,828.63
210101	Үндсэн цалин	270,797,261.20	304,051,369.94
210102	Нэмэгдэл	177,319,653.21	297,533,228.82
210103	Унаа хоолны хөнгөлөлт	12,022,820.39	11,601,689.96
210104	Урамшуулал	34,134,066.38	67,054,539.91

2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	69,479,710.64	62,072,899.83
210201	Тэтгэврийн даатгал	48,106,410.84	42,209,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	5,343,700.00	4,965,699.87
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,274,300.00	2,483,399.96
210204	Ажилгүйдлийн даатгал	1,068,700.00	2,483,400.00
210205	Эрүүл мэндийн даатгал	10,686,599.80	9,931,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	37,262,153.44	37,049,754.65
210301	Гэрэл, цахилгаан	5,604,636.44	7,299,581.65
210302	Түлш, халаалт	27,697,237.00	27,585,793.00
210303	Цэвэр, бохир ус	3,960,280.00	2,164,380.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,137,392.60	24,425,403.40
210401	Бичиг хэрэг	6,055,000.00	3,691,450.00
210402	Тээвэр, шатахуун	9,000,000.00	8,900,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,584,203.60	2,894,395.40
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	145,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,353,189.00	8,819,558.00
2105	Нормативт зардал	74,318,163.00	103,082,594.77
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	59,335,933.00	85,929,900.82
210502	Хоол, хүнс	12,401,230.00	14,667,693.95
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,581,000.00	2,485,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,747,070.00	17,812,160.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	920,000.00	641,470.00
210604	Урсгал засвар	13,827,070.00	17,170,690.00
2107	Томилолт, зочны зардал	410,000.00	434,000.00
210702	Дотоод албан томилолт	410,000.00	434,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,839,437.00	2,948,886.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,897,200.00	2,006,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	720,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	124,749.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	107,237.00	97,737.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	55,000.00	-
210807	Газрын төлбөр	60,000.00	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,509,080.00	1,462,780.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,509,080.00	1,462,780.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	8,004,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	8,004,000.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	8,004,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	26,794,946.56	21,275,245.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	26,794,946.56	21,275,245.35
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(82,608,752.06)	(100,913,731.73)
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	13,009,900.00	3,909,980.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	13,009,900.00	3,909,980.00
2200	Дотоод эх үүсвэрээр	13,009,900.00	3,909,980.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	13,009,900.00	3,909,980.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(13,009,900.00)	(3,909,980.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(95,618,652.06)	(104,823,711.73)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	200,442,363.79	104,823,711.73
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	104,823,711.73	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	496,688,078.57	1,073,638,299.90
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	496,688,078.57	1,073,638,299.90
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт бууралт	-	-	-	-
5	Үндсэн хөрөнгийн есөлт бууралт	-	-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
7	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
8	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
9	Тайлант үеийн үр дүн	-	-	(151,967,683.02)	(151,967,683.02)
10	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	344,720,395.55	921,670,616.88
11	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	344,720,395.55	921,670,616.88
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	344,720,395.55	921,670,616.88
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний есөлт бууралт	-	-	-	-
15	Үндсэн хөрөнгийн есөлт бууралт	-	-	-	-
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
17	Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-
18	Зарласан ногдол ашиг	-	-	-	-
19	Тайлант үеийн үр дүн	-	-	8,719,261.58	8,719,261.58
20	2024 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	156,678,198.05	420,272,023.28	353,439,657.13	930,389,878.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,073,574,100.00	941,443,287.28	(132,130,812.72)	87.69
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,073,574,100.00	941,443,287.28	(132,130,812.72)	87.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,057,566,100.00	933,439,287.28	(124,126,812.72)	88.26
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	715,167,800.00	680,240,828.63	(34,926,971.37)	95.12
210101	Үндсэн цалин	319,478,200.00	304,051,369.94	(15,426,830.06)	95.17
210102	Нэмэгдэл	308,889,200.00	297,533,228.82	(11,355,971.18)	96.32
210103	Унаа хоолны хөнгөлөлт	14,264,000.00	11,601,689.96	(2,662,310.04)	81.34
210104	Урамшуулал	72,536,400.00	67,054,539.91	(5,481,860.09)	92.44
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,966,300.00	62,072,899.83	(25,893,400.17)	70.56
210201	Тэтгэврийн даатгал	59,817,000.00	42,209,100.00	(17,607,900.00)	70.56
210202	Тэтгэмжийн даатгал	7,037,300.00	4,965,699.87	(2,071,600.13)	70.56
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,518,700.00	2,483,399.96	(1,035,300.04)	70.58
210204	Ажилгүйдлийн даатгал	3,518,700.00	2,483,400.00	(1,035,300.00)	70.58
210205	Эрүүл мэндийн даатгал	14,074,600.00	9,931,300.00	(4,143,300.00)	70.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,551,500.00	37,049,754.65	(19,501,745.35)	65.52
210301	Гэрэл, цахилгаан	11,069,500.00	7,299,581.65	(3,769,918.35)	65.94
210302	Түлш, халаалт	38,360,000.00	27,585,793.00	(10,774,207.00)	71.91
210303	Цэвэр, бохир ус	7,122,000.00	2,164,380.00	(4,957,620.00)	30.39
2104	Хангамж, бараа материалын зардал	34,448,400.00	24,425,403.40	(10,022,996.60)	70.90
210401	Бичиг хэрэг	5,601,100.00	3,691,450.00	(1,909,650.00)	65.91
210402	Тээвэр, шатахуун	9,334,000.00	8,900,000.00	(434,000.00)	95.35
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,895,200.00	2,894,395.40	(804.60)	99.97
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,670,900.00	120,000.00	(2,550,900.00)	4.49
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,947,200.00	8,819,558.00	(5,127,642.00)	63.24
2105	Нормативт зардал	126,951,300.00	103,082,594.77	(23,868,705.23)	81.20
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	109,632,300.00	85,929,900.82	(23,702,399.18)	78.38
210502	Хоол, хүнс	13,944,000.00	14,667,693.95	723,693.95	105.19
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,375,000.00	2,485,000.00	(890,000.00)	73.63
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	28,577,000.00	21,722,140.00	(6,854,860.00)	76.01
210601	Багаж, техник, хэрэгсэл	6,202,000.00	1,801,450.00	(4,400,550.00)	29.05
210604	Урсгал засвар	22,375,000.00	19,920,690.00	(2,454,310.00)	89.03
2107	Томилолт, зочны зардал	1,689,000.00	434,000.00	(1,255,000.00)	25.70
210702	Дотоод албан томилолт	1,689,000.00	434,000.00	(1,255,000.00)	25.70
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	4,714,500.00	2,948,886.00	(1,765,614.00)	62.55

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,121,100.00	2,006,400.00	(1,114,700.00)	64.29
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	800,000.00	720,000.00	(80,000.00)	90.00
210803	Даатгалын үйлчилгээ	250,000.00	124,749.00	(125,251.00)	49.90
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	97,737.00	(102,263.00)	48.87
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	150,000.00	-	(150,000.00)	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	43,400.00	-	(43,400.00)	-
210807	Газрын төлбөр	100,000.00	-	(100,000.00)	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	50,000.00	-	(50,000.00)	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,300.00	1,462,780.00	(37,520.00)	97.50
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,500,300.00	1,462,780.00	(37,520.00)	97.50
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,008,000.00	8,004,000.00	(8,004,000.00)	50.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	16,008,000.00	8,004,000.00	(8,004,000.00)	50.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	16,008,000.00	8,004,000.00	(8,004,000.00)	50.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,073,574,100.00	828,615,575.55	(244,958,524.45)	79.91
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	69,051,500.00	47,776,254.65	(21,275,245.35)	100.00
320001	Орон нутгийн төсвөөс	69,051,500.00	47,776,254.65	(21,275,245.35)	100.00
33	НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	883,690,900.00	780,839,320.90	(102,851,579.10)	88.36
330002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	883,690,900.00	780,839,320.90	(102,851,579.10)	88.36
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	120,831,700.00	8,004,000.00	(112,827,700.00)	6.62
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,008,000.00	8,004,000.00	(8,004,000.00)	50.00
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	104,823,700.00	-	(104,823,700.00)	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	104,823,711.73	104,823,711.73	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	47.00	7,611.00	7,564.00	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.50	21.50	(4.00)	84.31
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	19.50	15.50	(4.00)	79.49
620003	Үйлчлэх ажилтан	5.00	5.00	-	100.00
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	7,567.00	7,567.00	-
640001	Улсын эмнэлгээр хэвтэн эмчлүүлэгсдийн тоо	-	446.00	446.00	-
640002	Улсын эмнэлгийн амбулатороор эмчлүүлэгсдийн тоо	-	7,121.00	7,121.00	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	25.50	21.50	(4.00)	84.31
650008	Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ)	20.50	16.50	(4.00)	80.49
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	5.00	5.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан байхгүй

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төв нь эрхэм зорилгоо "Эрүүл мэндийн төвийн бүх төрлийн нөөцийг чадавхжуулан, хүн ам ялангуяа зорилтот бүлгийн иргэдийн эрэлт хэрэгцээнд тулгуурласан, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанар, үр дүн, хүртээмжтэй үзүүлж, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэхэд оршино" гэж тодорхойлсон байдаг.

Тус байгууллага нь эрүүл мэндийн төвийн яаралтай тусламжийн чадавхыг дээшлүүлэх, халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, үзлэгийг сайжруулах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, шилэн дансны тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд, байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар, 2024 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуулиар тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;
- Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 82 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд 2024 оны 1 дүгээр сарын 17-ны өдрийн хуулиар, 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Нийгмийн даатгалын ерөнхий хуульд 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд 2024 оны 6 дугаар сарын 05-ны өдрийн хуулиар нэмэлт өөрчлөлт оруулсан;
- ЭМДҮЗ-ийн 2024 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 06 дугаар тогтоол "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай";
- ЭМДҮЗ-ийн 2024 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 14 дүгээр тогтоолоор "Жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам шинэчлэн батлах тухай" тогтоолд нэмэлт өөрчлөлт оруулсан;

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дархан-Уул аймгийн Орхон сумын эрүүл мэндийн төв нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

Санхүүгийн тайланг нийт 57,494.9 мянган төгрөгийн алдаатай тайлагнасан нь УСНББОУС 1 "Санхүүгийн тайлангийн толилуулга", УСНББОУС 12 "Бараа материал", УСНББОУС 17 "Үндсэн хөрөнгө", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журмын 8, 10 дугаар бүлэг "Ангилал", "Толилуулга" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байгаа тул санхүүгийн тайланг залруулав.

5.1 Төлбөрийн акт

1. Дархан-Уул аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас тогтоосон 1,049.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг хариуцагч нараар төлүүлээгүй байна. Энэ нь Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5-д "Захирлын гэм буруутай үйл ажиллагаа болон энэ хууль, гэрээнд заасан эд хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхээ хэтрүүлэн буюу урвуулан ашиглах зэргээр тухайн үйлдвэрийн газарт хохирол учруулсан бол уг хохирлыг захирал өөрийн хувийн өмчийн эд хөрөнгөөр бүрэн хариуцна" гэсэн заалтуудтай нийцэхгүй тул хариуцагч нараар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2. Эрүүл мэндийн төвийн даргын тушаал шийдвэргүйгээр нягтлан бодогч Г.Алтанзулд 1,400.0 мянган төгрөгийн нэмэгдэл цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудтай нийцэхгүй тул төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

1. Өмнөх аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас авлага, өр төлбөр үүсгэсэн зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд 3,181.5 мянган төгрөгийн авлага үүсгэсэн тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ...бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэсэн заалтыг үндэслэн Эрүүл мэндийн төвийн нягтлан бодогч Г.Алтанзулд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

2. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр жилийн эцсийн тооллогын үр дүнг 12 сарын 31-ний үлдэгдлээр тохируулаагүй, тооллогын илтгэх хуудас болон тайланг үндсэн хөрөнгө, бараа материалын ангилал тус бүрээр дэлгэрэнгүй бодитой бичээгүй, өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт, тооллогын комиссын тайлан мэдээг цаг хугацаанд нь тайлагнаж дүгнэлт гаргаагүй, тооллого хийсэн протокол нь тооллогын шаардлагад нийцээгүй байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67.2-т "Өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалт бүртгэлээр тавих хяналтыг ерөнхий нягтлан бодогч хариуцна", 70.2-т "Эд хөрөнгийн дотоодын тооллогыг төрийн өмчит хуулийн этгээдийн захиргаа эрхлэн тогтоосон хугацаанд явуулж, улирал жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлагнах", 72.4-д "Эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв чанартай явуулж дуусгах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан мэдээг үнэн зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтуудыг зөрчсөн ба Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын 4.2.1.10."аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг үндэслэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

3. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан бараа материалын орлого, зарлагыг ажил гүйлгээг бараа материалын тайланд гүйлгээ гарах бүрд хөдөлгөөн хийдэггүй, анхан шатны баримтгүй, урсгал зардалд зарцуулсан материалын ажлын тайлан гүйцэтгэлгүй 12,672.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийн үнэн зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.9. "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг

хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах", Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8 дугаар бүлэгт "Бараа материалыг ангилж бүртгэхдээ дансны нэгдсэн жагсаалт болон холбогдох УСНББОУС-ыг стандартыг мөрдөнө" гэсэн заалтуудыг зөрчсөн ба Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны 12 дугаар сарын 9-ний өдрийн А/95 дугаар тушаалын 4.2.1.10."аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтыг үндэслэн зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

4. Эрүүл мэндийн төвийн эмч, эмнэлэгийн ажилтан нарт улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 22,672,000.00 төгрөгийн мөнгөн урамшуулал олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-т "Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 3.7-д "Ажлын үр дүнгийн үнэлгээнээс хамааран дараахь хувь хэмжээгээр сар бүр мөнгөн урамшуулал тооцно" гэж заасантай тус тус нийцээгүй тул зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Өр төлбөрийн данстай холбоотой асуудал

Харилцагч байгууллагатай тооцоо нийлээгүй, төсвийг зохистой удирдаагүйгээс өр төлбөр үүссэн, 2022 онд худалдан авсан эмийн үлдэгдэл 2,300.0 мянган төгрөгийг тооцооны дансаар дамжуулаагүй, шууд зардлаар бүртгэн шилжүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2 "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх" 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.1 "аж ахуйн бүх ажил, гүйлгээ", 14.4.5."бүх орлого" 20 дугаар зүйлийн 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг зөрчсөн ба "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй, анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэх.

2. Цалингийн данстай холбоотой асуудал

Эрүүл мэндийн төвийн их эмч Х.Билгүүнд суралцаж байх хугацаанд цалинг бүтэн цагаар бодож 8,837.3 мянган төгрөгийн цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 5.1.5-д "хариуцлагатай байх", 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16.5.2-д "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", Дархан-Уул аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудын Үйлдвэрчний эвлэлийн хорооны хооронд 2023-2024 онд байгуулсан хамтын гэрээний 4.8.12 "Магистр, Докторын зэрэг хамгаалах гэж буй ажилтанд нотлох баримтыг үндэслэн ажлын 5 хоног" гэсэн заалтуудтай нийцэхгүй ба "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй, анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэх.

3. Бусад хууль тогтоомжийн хэрэгжилт

Тус төв нь хууль тогтоомжийн хүрээнд ахмадын сан байгуулаагүй нь Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7 дахь "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган, цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Ахмадын сан байгуулан ажиллуулах журмын 1.3 дахь "Төсөвт байгууллагын тухайд цалингийн сангийн гурав хүртэлх хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр сан байгуулж, шаардагдах хөрөнгийг төсөвтөө жил бүр тусгана" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу ахмадын санг байгуулах, мөн алдааг давтан гаргахгүй анхаарч ажиллах зөвлөмж хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 -д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Дансны гүйлгээ буруу хийсэн	1	1,257.7			1	1,257.7	1	1,257.7				
Үндсэн хөрөнгийг орлого аваагүй.	1	3,066.2	1	3,066.2			1	3,066.2				
Элэгдэл дутуу тооцсон	1	1,401.3			1	1,401.3	1	1,401.3				
Төвлөрүүлэх шилжүүлгийн гүйлгээ буруу хийсэн.	1	21,275.2			1	21,275.2	1	21,275.2				
Хуримтлагдсан үр дүнг зөрүүтэй илэрхийлсэн.	1	26,794.9			1	26,794.9	1	26,794.9				
Худалдан авсан хөрөнгийг буруу бүртгэсэн	1	2,750.0			1	2,750.0	1	2,750.0				
Мөнгөн гүйлгээний тайланд зөрүүтэй илэрхийлсэн.	1	949.6			1	949.6	1	949.6				
	7	57,494.9	1	3,066.2	6	54,428.7	7	57,494.9	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
							Зөвлөмж					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төлбөрийг актыг хариуцагч нараар төлүүлээгүй	1	1,049.5	1	1,049.5								
Үндэслэлгүй нэмэгдэл цалин бодож олгосон	1	1,400.0	1	1,400.0								

Авлага, өр төлбөр үүсгэсэн	1	3,181.5							1	3,181.5		
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээ гүй	1	0.0			1	0.0						
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээ гүй	1	12,672.7			1	12,672.7						
Урамшуулл ыг цалингийн сангаас олгосон байна.	1	22,681.6			1	22,681.0						
Тооцооны дансаар дамжуулааг үй	1	2,300.0					1	2,300.0				
Цалинг бүтэн цагаар бодож олгосон	1	8,837.3					1	8,837.3				
Дүн	8	52,122.6	2	2,449.5	3	35,353.7	2	11,137.3	1	3,181.5	0	0

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д заасан цалингийн зардлаас бусад орлогын 32,037.6 мянган төгрөгийн 8 гүйлгээг мэдээлээгүй байна.	1	32,037.6			1	32,037.6		
Дүн	1	32,037.6	-	-	1	32,037.6		
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Ахмадын сөн байгуулаагүй.	1	0.0					1	0.0
Дүн	1	0.0					1	
Нийт дүн	2	32,037.6	-	-	1	32,037.6	1	0.0